

ХҮННҮГИЙН ХҮН АМЫН ТООНЫ ТУХАЙ

Б.БАТСҮРЭН

*ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Эртний түүхийн салбар,
e-mail: bbarangas@yahoo.com*

Хүннү гүрэн оршиж тогтносон гурван зуу илүү жилдээ, Төв Азийн хэр олон оршин суугчдыг өөрийн улс гүрэндээ нэгтгэж байсан, түүний дотор *хүннүчүүд* хэдүүлээ байсан талаар энэ илтгэлд товч өгүүлэхийг зорилоо.

Хүннүгийн хүн амын талаарх судалгааг:

Нэгд, түүх сударт үлдсэн тоо баримтад түшиглэн Хүннү гүрний хүн амыг тоог тогтоодог уламжлалт арга хэрэглэсэн судалгаа,

Хоёрт, Монгол орны бэлчээрийн даацыг харгалзан нийт малын тоо толгойг тооцоолж, тэр нь хэдүй хэрийн хүнийг хооллож, гэжээхийг харгалзсан судалгаа хэмээн үндсэнд хоёр ангилж болох юм.

Эхний чиглэлийн судалгааны жишээг В.С.Таскиний түүвэрлэн орчуулсан, «Материалы по истории сюнну (по китайским источникам)» эмхтгэлийн дэд дэвтрийн 5-6-р талаас харж болох бол сүүлийн аргыг хэрэглэсэн үлгэрийг Н.Н.Крадин. «Империя Хунну» зохиолын 71-79-р талаас үзэж болно.

Нэгдүгээр чиглэлийг баримтлагчид, м.э.ө. 201 онд Хань улсын хаан Лю Баньг Байдэн ууланд, 4 эсвэл 3 бум цэргээр бүсэлсэн гэх мэдээг үндэслэн 1.2-1.5 сая хүнтэй байсан гэж үздэг. Тухайлбал, Ма Чаншоу “Маодунь, Лаошан хоёр шаньюйн үе Хүннү улсын мандалтын үе мөний зэрэгцээгээр, ... Хүннүгийн мандалтын үеийн хүн амын талаар хүннүгийн тухай бүлэгт «Маодунь 300000 нумт, сумт цэрэгтэй» гэсэн. Цэрэг бүрийг өрхийн хүн ба боолоор дунджаар таван хүнээр бодож гаргадаг болохоор хүннүгийн нийт хүн 1500000 байна” гэжээ (Сүхбаатар, 1980: 87).

Хүннүгийн хүн амын судалгаанд: нэгд, бэлчээр түүнээс хамаарах малын тоо толгой, үүнээс хүн амын тоо хамаарахыг, хоёрт, нүүдэллэх янз бүрийн аргын алинийг *хүннүчүүд* хэрэглэж байсныг, гуравт, байгалийн гэнэтийн томоохон өөрчлөлт, ган, зуд гэх мэт, дөрөвт, нүүдэлчдийн хэвийн амьдрал, ахуйг хэв маягийг огцом, гэнэт эвдэж, өөрчлөх нийгмийн ялангуяа улс төрийн үйл явдлыг харгалзвал үнэнд дөхсөн тоо баримтыг гаргаж боломжтойг сануулсан, хоёрдугаар чиглэлийн нэг төлөөлөгч, Н.Н.Крадин, бэлчээр, мал, хүн гурвын харилцан

шүтэлцээг харгалзсан тооцоолох аргаар *хүннүд** 350-800 мянган хүн аж төрж байсан, түүнчлэн *хүннүд* Монголоос гаднах нутгийн хүн ам харьяалагдаж байсныг тооцвол 1-1.5 сая гэж үзэх нь дэгсдүүлсэн тоо биш гэжээ (Крадин, 2001: 71-79).

Энэ хоёр аргад ололттой, дутагдалтай тал бий.

Маодунь болон Лаошан шаньюйн үест *хүннүчүүд* Төв Азийн томоохон аймаг, улсуудыг ээлж дараалан эзэлжээ. Сударт тэмдэглэсэнээр, *хүннүчүүд* анх дорнод хөрш *дунхуг* бутцохижээ (Материалы по истории сюнну, 1968: 39). Харин *дунхуг* «хүннүтэй нэг зэрэг мандан гарсан бөгөөд нум, сумт цэрэг хоёр бум гаруй буй» хэмээн түүхэнд тэмдэглэжээ (Сүхбаатар, 1971: 24). *Дунхуг* бутцохиж үлдэгдэл нь *сяньби*, *ухуань* аймаг болсныг хураан эзэлсний дараа *хүннүчүүд* өрнө зүг цэрэглэн *юэжи* аймгийг довтолжээ. *Их юэжи* аймаг бум гаруй өрхийн дөрвөн бум хүнтэй, буман шилдэг цэрэгтэй гэх мэдээ түүх сударт үлджээ (Бичурин, 1950: том II, с. 183).

Юэжи аймгийг бутцохисон *хүннүчүүд* дараа нь Ордосоор нутаглах *лоуфань*, *байян* аймгийг өөртөө нэгтгэв. Тус хоёр аймаг хэдий хэрийн хүн амтай байсныг гэрчлэх баримт хараахан алга, таамаглахад арваад мянган хүнтэй байж болох юм. Маодунь дараа нь *хуньюй*, *цойшэ*, *динлин*, *гэгунь*, *синьли* аймгийг эзэлж нутаг дэвсгэрээ өргөтгөсөн ба харин м.э.ө. 176 онд *лоулань*, *усунь*, *хуцзе* хийгээд тэдэнтэй хил залгаа 26 эзэмшлийг байлдан хурааж цөмий нь Хүннүгийн харьяат болгосон юм (Материалы по истории сюнну, 1968: 39, 41, 43). М.э.ө. 204-201 оны хооронд эзэлсэн 5 аймгаас *динлин*, *гэгунь* нарт холбогдох мэдээ бий. Гэхдээ энэ мэдээ нэлээд хожмынх (м.э. III зуун) ажээ. Түүнд, “*цзяньгунь* (*гэгунь*) нь *канцзюйн* баруун хойно байдаг, шилдэг цэрэг 3 түм буй, ... *динлин* нь *канцзюйн* хойно оршино, 6 түм шилдэг цэрэгтэй” (Chavannes, 1905: 559-560) гэж өгүүлжээ. Харин м.э.ө. 176 онд Хүннүгийн харьяат аймгаар дурдагсад дотроос *усунь* аймгийн талаар дараах зүйлийг хэлье. *Юэжи* нарт довтлуулж, зугтан улмаар Хүннүгийн өмгөөлөлд орсон *усунь* аймаг м.э.ө. 170-160 аад оны, Хүннүгээс баруун зүгт хийсэн дайнаар одоогийн Долоон Усны хөндийд нутаглах болсон. Уг нутаг сууж байсан *сак*, *юэжи* аймгийн үлдэгдлийг *усуньчууд* өөртөө нэгтгэж, Хүннүгийн баруун хилийг хамгаалан, м.э.ө. II зууны сүүл хүртэл Хүннү гүрний харьяанд багтаж байлаа. Түүхэнд *усунийг* 120 мянган өрхийн 630 мянган хүн амтай, 188 мянган шилдэг цэрэгтэй гэж бичжээ (Бичурин, 1950: Том II, с. 190). *Хуцзе* аймгийг хожмын сурвалжийн *хүдэ* аймаг мөн гэж үзвэл, тэд “Цунлиний ард, *усуний* баруун хойно, *канцзюйн* зүүн хойно байдаг, түмэн шилдэг цэрэгтэй.” (Chavannes, 1905: 559). Лоб нуур, Таримын савд орших *лоулань*-ийг бас *шаньшань* гэнэ, 1500 өрхийн 14100 хүн ам, 2912 цэрэг эртэй (Бичурин, 1950, Том II, с. 173). Харин *лоулань*, *усунь*, *хуцзе* болон *хүннүгийн* хооронд Тэнгэр уулын бүс нутагт орших 26 хот-улсад, түүх сударт тэмдэглэсэнээс Л.А.Боровковагийн түүвэрлэсэнээр бол

* Гэхдээ энэ нь одоогийн Монгол Улсын нутаг болохыг тэрээр цохон тэмдэглэжээ.

37447 өрхийн 298498 хүн ам оршин сууж байжээ (Боровкова, 2001: 317-318, приложения, табл. 4).

Сурвалжид дурдсан мэдээг үндэслэвэл, Хүннү гүрэн м.э.ө. 204-176 оны хооронд нийт 653951 цэрэг гаргаж чадах *дунху, их юэжи, гэгунь, динлин, усунь, хуцзе/худэ, лоулань* болон баруун газрын 26 улс, аймагтай байлдаж, заримыг нь эзэлж заримыг нь суугуул нутгаас нь үлдэн хөөжээ. Энэ тоонд хүн амын тоо нь үл мэдэгдэх *лоуфань, байян, хуньюй, цюйшэ, синьли* аймгийн цэргийг оруулаагүй байгааг анзаарна уу.

Харин сурвалжийн мэдээгээр хүннүд энэ үед 400000 эсвэл 300000 (Материалы по истории сюнну, 1968: 41), бас 60000 (Материалы по истории сюнну, 1973: 5), эсвэл 140000 (Боровкова, 2001: 57) цэрэг байсан гэдэг.

Их төлөв утга үсгийн бичгийн дурсгалд үлдсэн Хүннү гүрний хүн амын тооны талаар баримжаа олгох дээрх мэдээнүүдийг базаж үзвэл маш өндөр тоо гарч байгаа нь эдгээр мэдээний аль нь бодитой аль хэсэг нь дэгс, хуудуу болохыг нягтлах шаардлагыг судлаачдын өмнө эрхгүй дэвшүүлж байна.

Хүннүгийн хамгийн анх эзэлсэн *дунхуг* түүх сударт 2 бум нум, сумт цэрэгтэй гэж буй ч тэдний удмын *ухуань* аймаг, м.э. 168-190 онд хамаарах мэдээгээр 16800 өрхтэй байсан бол м.э. II зууны дундуур *сяньбид* 50 гаруй угсаан-ийтлэгийн томоохон нэгж байсныг сурвалжууд гэрчилдэг (Таскин, 1980: 76, 84). Түүнчлэн 107-113 онд хамаарах мэдээгээр *сяньбийн* 120 овог/хүрээ Хань улсад хүн илгээж байсан бол 123 онд нэг түм, 127 оны хавар Ляодуны *сяньбийн* зургаан мянган морьтон, Хань улсын хилд халдаж байсан ба 3 түм хүнтэй *сяньбийн* том бүлэг 127 онд Ляодунд нүүж ирж байсан гэх хэсэг бусаг мэдээ бий (Материалы по истории Дунху, 1984: 72, 73, 74). Чингэлээр *сяньби* аймагт хэдий хэрийн хүн байсныг багцаалах боломжийг 120 гаруй овог-хүрээ, эсвэл 50 иад аймаг байсан гэх мэдээ л олгох болж байна.

Юэжи аймгийн хувьд *хүннүчүүд, юэжи* нартай м.э.ө. 202-201 оны үед, м.э.ө. 176 онд, бас м.э.ө. 167 оны үест гурван удаа зэвсэг зөрүүлж байж сая нэг ялалтад хүрч, эхлээд Алаша, Наньшань, Эзний голын сав нутгаас хожим Зүүнгар, Долоон Усны хөндийгөөс Дундад Азийн нутаг руу үлдэн хөөж байв. Тиймээс Хүннүгийн мэдэлд *юэжи* аймаг бүрэн орсон гэж үзэх нь оновчгүй, харин Наньшань уулийн бэлд үлдэж хоцорсон *бага юэжи* нарыг Хүннүгийн харьяанд байсан гэж үзвэл зохилтой. Гэхдээ үлдсэн *бага юэжи* нарын хүн амын тоог илтгэх сурвалжийн мэдээ бараг байхгүй.

Хүннүгийн баруун болон ар хэсгээр нутаглаж байсан *хуньюй, цюйшэ, динлин, гэгунь, синьли* аймгаас тодорхой баримт, тоо мэдээ үлдээсэн нь *гэгунь, динлин* гэдгийг дээр хэлсэн. Сурвалжид *гэгунь* аймгийг 3 түм цэрэгтэй гэдэг ч Соёны нурууны ар, Мини-Усын хотгорт 1703 оны үед 3-4 мянган өрх *киргиз*, харин Соёны нурууны өвөр Танну Урианхайд 1842 оны байдлаар 6450 өрх

тувачууд нутаглаж байсан гэж Н.А.Аристов бүтээлдээ тэмдэглэснийг (Аристов, 1896: 394, 347) үндэслэвэл Соёны нурууны ар, өвөрт 15, дээд тал 20-иод мянган өрх айл нутаглах бололцоотой байх нь.

М.э. III зууны үеийн сурвалжид, *динлин* аймгийг 6 түмэн цэрэгтэй хэмээжээ. *Динлиний* удмын *өндөр тэрэгтэн* аймгуудын талаар хамгийн найдвартай, цэгцтэй мэдээг үлдээсэн «Сүй шу» хэмээх сударт Монгол, Алтай, Зүүнгар, Тэнгэр уулаар нутаглах *өндөр тэрэгтэн* аймгуудын нийт цэргийг 5 түм гэсэн байдаг (Чэн Чжунмянь, 1958 (2004): 662-668, 676 [хятад хэлээр]). Энэ үед *өндөр тэрэгтэн* аймгууд илүү хүчирхэг, нутаглах газар орон уудам, дэлгэр байв. Гэтэл *хүннүгийн* үеийн *динлин* "... тэднийг *усуниас* зааглах Борхорын нуруунаас хойш, Зостын элснээс баруунаа (хэвлэлийн алдаа, уг нь дорно зүг бололтой-Б.Б.) өөрөөр хэлбэл, Баруун Монголын Их нууруудын хотгороор нутаглаж" (Боровкова, 2001: 296) байв. Хожмын *өндөр тэрэгтэн* аймгуудаас бага хэмжээтэй нутагт сууж байсан *динлин* 6 түм цэргийг дайны цагт гаргана гэдэг нь хэн бүхэнд үнэмшил муутай сонсогдох байх. Тиймээс м.э.ө. III-II зууны үест нэр гарсан *динлин* аймагт 5 түмээс доош тооны цэрэг байсан гэж үзэх нь үнэнд ойр болов уу.

Усунь аймгийн тухайд гэвэл тэд хэдийгээр Хүннүд харьяалагдаж байсан боловч, Лаошан шаньюй нас барсны хойно аажмаар Хүннүгийн эрхшээлээс ангижирч улмаар м.э.ө. II зууны сүүлээр бараг бие даажээ. Тэгээд ч *усунь* аймаг анх *юэжийн* жижиг аймаг байж байгаад Долоон Усны хөндийд ирээд уугуул *сак* аймгийн үлдэгдэл мөн *юэжи* нарын нүүж амжаагүй хэсгийг өөртөө нэгтгэсэн тул *усуньчууд* анх Хүннүд харьяалагдаж байхдаа хэдий хэрийн хүн амтай байсныг тогтоох боломж алдагдаж байгаа юм.

Түүх сударт үлдсэн тоо баримтын эсрэг гаргаж тавьж буй бидний товч төдий эсрэг-саналыг харгалзвал, Хүннүгийн хүн амын тоог тогтооход өөр арга хэрэглэх хэрэгтэй болж байна.

Өөр нэг арга, зам нь Хүннү гүрэн харьяалагдах аймаг, угсаатан буюу тогтвортой оршиж ирсэн тэдний угсаа-нийтлэгийн нэгжид багтах хүн амын тоогоор баримжаалах явдал. Гэхдээ эл аргад дутагдалтай тал бий, тухайлбал, түүх сударт бүх овог, аймгийн нэрийг бүрэн жагсаасан мэдээ сэлт ховор. Тэрчлэн *нангиад* сурвалжид үлдсэн угсаа-нийтлэгийн нэгжийн (種-жун, 部落-було, 姓-шин гэх мэт) нэрсийг хэрхэн ойлгох, тухайн нэрээр хэдий хэрийн хүнтэй, угсаатны ямар бүлэглэлийг оноож байгаа тухай асуудал босч ирнэ. Тэгээд ч эрдэмтэд эдгээрийг янз бүрээр тайлбарласаар ирсэн билээ (Батсүрэн, 2009: 176-178). Энэ бүхнийг түр орхин тухайн аргаар Хүннүгийн хүн амын тоог ойролцоогоор тогтоох боломж бий эсэхийг сонирхье.

Ер нь *хүннүгийн* түүхэнд холбогдох *нангиадын* голлох сурвалжуудад, *хүннү* нартай нэр холбож, өөрөөр хэлбэл тэдний төр улс, улс төрийн түүхийн үйл явц, өрнөлийн талаар өгүүлэхдээ нийтдээ жар гаруй овог, аймгийн нэрийг долоон

зуугаад жилийн хугацаанд тархааж тэмдэглэжээ. Харин м.э.ө. III - м.э. I зууны үед холбогдуулан дараах:

а/. *люаньти (сюйляньти), хуянь, лань (улолань), сюйбу, сютүгэ (сючүгэ, түгэ), хуньшэ (хунье, кунья), вэньоуто (вэньюйти, вэньюйду, вэньду), сижсу, юйцзянь, гуси,*

б/. *цюлинь, цзилюсы, цюйлань, чуби, худусюй, шюйцзы, удуцзюй, ханьши, данюй, ланьши, лицзе* гэсэн 21 нэрийг тэмдэглэжээ.

Мөн язгууртныг нэрлэхдээ толгойлж, тэргүүлж байсан овог, аймгийг дурдаж байсан гэх Г.Сүхбаатар багшийн саналыг дагавал: *луту, пуинь, люю, ти, хэсу, юйтучучань, имоцзы, лихань* зэрэг 8 овог эсвэл аймгийг *хүннү* аймгийн тоонд оруулж болно. Чингэвэл, нийт 29 *хүннү* овог, хүрээ болон аймгийн нэрийг бид мэдэх боллоо.

Анхаарах нэг зүйл байгаа нь эдгээр 29 нэрээс хэд нь жинхэнэ аймгийн нэр, хэд нь урагийн нэр, хэд нь томоохон өөр угсаа-нийтлэгийн нэгжийг зааж байгааг ялгаж салгах хэрэгтэй. Тухайлбал, *люаньти (сюйляньти), хуянь, лань (улолань), сюйбу* нарыг ихэнх эрдэмтэд овог (фамилий) гэж үздэг. Энэ жишээгээр *луту, пуинь, люю, ти, хэсу, юйтучучань, имоцзы, лихань* зэрэг нь мөн урагийн нэр болж болох юм. Эл байдлыг харгалзан үзвэл *хүннү* аймгийн тоо 17 орчим болох бололтой.

М.э. I зууны дөчөөд онд холбогдох нэгэн мэдээнд, шаньюй сууж чадаагүй *хүннүгийн* өмнөд хязгаарыг захирагч жижу ван Би, *хүннүгийн* өмнөд хязгаарт нутаглах, 40-50 мянган цэрэг гаргадаг 8 аймгийн язгууртныг хуралдуулан өөрийгөө шаньюй өргөмжилжээ (Материалы по истории сюнну, 1973: 70-71). Тус мэдээг үндэслэвэл нэг аймаг 5-6250 орчим цэргийг дайнд мордуулдаг болж таарч байна.

М.э. 50 оны зун, урьд өмнөд *хүннүд* олзлогдсон, Умард Хүннүгийн зүүнгарын Юцзянь сянь-ван өөрийн таван гудухуу түшмэл, 30 гаруй мянган хүнээ дагуулан говийн хойно нүүж гарсан бол 83 онд Санмулоуцзы уулын хавьд нутаглаж байсан умард хүннүгийн язгууртан 38 мянган хүнээ дагуулан Хань улсад иржээ. Харин Умард Хүннүгийн зүүнгарт довтолсон сяньби нарын уулгаас дутааж *цюйлань, чуби, худусюй* зэрэг 58 овгийн (部бу буюу хүрээ?) 2 бум хүн, 8 мянган цэрэг Хань улсын Юньчжун, Уюань, Шофан, Бэйди тойрогт нүүн ирэв (Материалы по истории сюнну, 1973: 72, 79, 81).

Дээрх хэрэглэгдэхүүнээс ажвал нэг аймаг (種-жун) 25 эсвэл 30/31/38 орчим мянган хүнтэй байсан бололтой. Харин нэг бу (部) буюу було (部落) нь 3440-ээд хүнтэй байгаа нь дундад эртний *монголчуудын* хүрээний тоотой тун ойролцоо байна. Тэгээд ч Г.Сүхбаатар абугай “«бу» гэж овог, аймаг мэтийн угсаатны нэгдлэгийг хэлээгүй нь маргаангүй. Түүнийг В.С.Таскин «кочевье» (нутаг, нүүдэл) гэж орчуулсан нь үнэнд нилээд дөхсөн байна. Барагцаалбал 3500 орчим

хүнтэй бүлэг нүүдэлчид хот ч бус, айл ч бус, харин Чингисийн үеийн «хүрээ» мөн бололтой” гэдэг (Сүхбаатар, 1980: 45).

Хүннүгийн нэг аймаг 25-31 мянган хүнтэй гэж сурвалжийн мэдээ өгүүлж байгаа ч зарим монгол судлаач нэг аймаг дунджаар 5000-6000 хүнтэй гэж үздэг (Ганболд, 1996: 69). Хожмын үед холбогдох Тан улсын хуучин, шинэ хоёр судрын мэдээгээр бол *ахуэй*, *чухэ*, *аоши*, *дуцзи*, *юаньсычжэ* гэх таван аймагтай *күмоси* 3 түм цэрэгтэй. Гэхдээ «Тан улсын шинэ судар»-т бас *күмоси* буюу *си* аймгийг 5 мянган өрхтэй гэж тэмдэглэжээ. Харин, Таван төрийн түүхэнд, 2 түм цэрэгтэй *күмоси*-д *ахуэй*, *чоми*, *аочжи*, *нуцзе*, *хэйцичжи* аймаг байдаг гэжээ. *Күмоси* аймгийн хөрш *хиданыг* мөнөөх Тан улсын хоёр түүхэнд дөч эсвэл дөчин гурван мянган шилдэг цэрэгтэй, *дацзи*, *хэбянь*, *духо*, *фэньвэнь*, *тубянь*, *жуйси*, *чжуйцзин*, *фу* гэсэн найман аймагтай гэж тэмдэглэн үлдээжээ (Материалы по истории Дунху, 1984: 144, 149, 151, 152, 156-157, 163, 164).

Күмоси болон *хидан* аймагт хамаарах мэдээнд нэг ижил төстэй зүйл байгаа нь нэг аймаг тухайн цагт 5-6 мянган цэрэг гаргадаг байж.

Хүннүгийн овог, аймаг түүнд хэдий хэрийн хүн байсан талаарх түүхийн мэдээ, судалгаанаас үзвэл аймаг мөн хүрээг үндэслэж Хүннүгийн хүн амын тоог гаргаж болох хэдий ч бас л учир дутагдалтай (гол нь *хүннү* аймаг эсвэл түүнд багтах хүрээ яг хэд байсныг гүйцэд илрүүлэх боломж маш хомс аж.) нь харагдаж байна.

Хүннүгийн хүн амын *судалгааны уламжлалт арга, бэлчээр-мал-хүн гэсэн шүтэлцээг харгалзсан тооцоолох арга болон аймаг, хүрээ зэрэг угсаан-нийтлэгийн нэгжид тулгуурласан дээрх гурван аргын* ололт, алдааг өгүүлсэн хэсгээс үзвэл Хүннүгийн хүн амын тоог, итгэж болох сурвалжийн мэдээнд тулгуурлан, гэхдээ дээрх гурван аргыг зэрэг хэрэглэж, тооцоолох нь хамгийн үр дүнтэй хувилбар гэдэг саналыг тэмдэглэн хэлэхээс аргагүйд хүрч байна.

Ийм боломжийг олгох мэдээ түүх сударт бий. Тухайлбал, м.э.ө. 167-166 оны өвөл “*сюннугийн* шаньюй 140 мянган морин цэргийн хамт Чжаона, Сяогуаньд цөмөрч, Бэйди-гийн дувэй захирагч Инь-ийг хороож, олон агт морь, мал сүрэг, эд бараа олзлоод дараа нь Пэнъянд дөхөж ирэв” (Боровкова, 2001: 57) гэсэн мэдээ бий. Мөн м.э. 80-аад оны сүүлээр “... умард шаньюй буруулав, харин үүнийг ашиглаж *сяньби* нар нүүн ирж түүний нутгийг эзлэв. *Хүннүгийн* бум гаруй өрх үлдэгдэл өөрсдийгөө *сяньби* хэмээн нэрийдэх болов” гэсэн өөр нэг мэдээ байдаг (Материалы по истории Дунху, 1984: 71). Тэрчлэн “энэ цаг дор өмнөд нүүдэлдчийн (ө.х. *хүннүгийн*) хүн ам, ... ихэд өсч 34 мянган өрх, 237300 хүн ам, 50170 цэрэгтэй болсон” гэх бас нэг мэдээ үлджээ. Өөрөөр хэлбэл, м.э.ө. II зууны дундуур Хүннү гүрэнд 700000 хүн ам харин м.э. I зууны дундуур умард, өмнөд гэж салсан хоёр Хүннүд нийтдээ 737000 хүн ам оршиж байжээ гэж үзэж болно. Гэхдээ энэ тоог Хүннү гүрний нийт харьяат олон хэлийн овог, аймгийн хүн ам гэж үзэх зүйтэй болов уу. Хүннү гүрэнд байсан 24 түмт нь бас тус улсын нийт хүн

амыг тоог гаргах нэг сэжүүр мөн. Гэхдээ нэг түмтийг шууд 10 мянга гэж ойлгох нь эндүүрэл, харин нэг түмт дунджаар 6 мянга орчим цэрэгтэй гэж үзвэл Хүннү гүрэнд 720 мянган хүн байжээ гэж хэлж болох юм.

Харин жинхэнэ *хүннү* аймгуудын хүн амыг тухайн цагт амьдарч байсан Хань улсын эрдэмтэн Цзя И (м.э.ө. 200-168 он) «Синь шу» хэмээх зохиолдоо хэлжээ гэж бид үзэж байна. Түүнд “миний тооцоогоор бол *хүннүд* нум сум татаж чадах 6 түм морьтон бий. Нэг хуягт эрд таван хүн оногдох тул нийт ард түмэн нь 3 бум болох нь жилд мянган дань буудайн хөлстэй захирагчийн даргалах Ханьгийн нэг хошуунаас бага хүн амтай” (Материалы по истории сюнну, 1973: 5) хэмээн өгүүлдэг. Энэ баримтыг зарим судлаачид, тухайлбал, В.С.Таскин үгүйсгэдэг. Түүний баримталдаг гол мэдээ, баримт нь Хүннүд амьдрах болсон хятад түшмэл Чжунхан Юэ-гийн үг болой. Чжунхан Юэ нь м.э.ө. 174 онд Хүннүгийн шинэ шаньюй Лаошанд, урьдын гэрээ ёсоор бэлэг сэлт, гүнж хүргэхээр томилогдсон ордны түшмэл бөгөөд Хүннүд ирсэн даруй Хань улсаас урваж Лаошанд алба хаших болжээ. Чингээд тэрбээр нэгэн удаа Хань улсын эд бараанд хэт дурлах болсон шаньюйд анхааруулж хэлсэн үгэндээ “одоо Хүннүгийн хүн ам Хань улсын нэг том мужийн хүн амаас бага” гэж өгүүлжээ. Эл баримтыг өлгөж авсан В.С.Таскин, «Хань шуд» тэмдэглэснээр бол, одоогийн Хөнань мужийн нутагт байсан Инчуань мужид 2210973, харин Жунаньд 2596148 хүн байсан гээд улмаар хүннүд 1.5 сая хүн амьдарч байсан гэжээ (Материалы по истории сюнну, 1973: 6). Харин бидний бодлоор В.С.Таскиний хэрэглэсэн дээрх хоёр мужийн хүн амын тоо нь их хожмын түүхэн мэдээ, өөрөөр хэлбэл, Хань улс ихэд хүчирхэгжиж хүн ам нь 50 сая давсан үеийн тоо баримтад тулгуурласан юм. Гэтэл, байлдаант улсын үеийн, Цинь улсын үеийн тэрчлэн Хань улсын хүн амын тоо тогтвортой байж чадаагүй. Байлдаант улсын үеийн 7 ванлигийн хүн амын тоо 20 саяыг давж байгаагүй гэж судлаачид үзжээ (Фань Вэнь-лань., 1958: 213; История Китая, 1974: 19). Бусад зургаан ванлигаа, Цинь улс эзэлж, нэгтгэх явцад хүн ам нь ихэд хэлмэгдсэн бол Цинь улс унаж, Хань улс байгуулагдах үйл явц, олон зуун мянган хүний амийг өгүүтгэсэн үйл хэргээр дүүрэн ажээ (Шан Юэ нар, 1959: 67). Тэгээд ч тулгар Хань улсын эдийн засаг, хүн ам тэр даруйдаа өсөж дэвжээгүй. Тиймээс, м.э.ө. II зууны дал, жараад онд Хань улс төдий хүчирхэгжиж чадаагүй бөгөөд харин Уди хааны (м.э.ө. 141-87 он) үед Хань улс Хүннүтэй дайн хийх чадалтай болж ирсэн байдаг. Үүний учир, м.э.ө. 200-168 оны үед амьдарч байсан Цзя И-гийн мэдээ нь үндсэндээ Хүннү гүрэнг байгуулсан жинхэнэ *хүннүчүүдийн* хүн амын тоо байж болох магадлал илт өсөх учиртай.

НОМ ЗҮЙ

Аристов Н.А., 1896. Заметки объ этническомъ составъ тюркскихъ племень и народностей и сведения объ ихъ численности. -Живая старина. Выпускъ III и IV. С-Петербургъ, сс. 277-456

- Батсүрэн Б.*, 2009. Өндөр тэрэгтнүүд ба эртний түрэгүүд (VI-IX зуун). Улаанбаатар, Мөнхийн үсэг.
- Бичурин Н.Я.*, 1950. (Иакинф) Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. Том II. Москва-Ленинград, Изд-во АН СССР.
- Боровка Л.А.*, 2001. Царства «Западного края» во II-I веках до н.э. Восточный Туркестан и Средняя Азия по сведениям из «Ши цзи» и «Хань шу». Москва, ИВ РАН, Крафт
- Ганболд Ж.*, 1996. Хүннүгийн цэргийн тогтолцоо. -Монгол цэргийн түүх судлал: өнөө ба ирээдүй. Улаанбаатар, 67-75
- История Китая с древнейших времен до наших дней*, 1974. Москва, Изд-во Наука, ГРВЛ
- Крадин Н.Н.*, 2001. Империя Хунну. Изд. 2-е, перераб и доп. Москва, Логос.
- Материалы по истории сюнну (по китайским источникам)*, 1968. Предисловие, перевод и примечания В.С.Таскина. Москва, Изд-во Наука, ГРВЛ
- Материалы по истории сюнну (по китайским источникам)*, 1973. Выпуск второй. Предисловие, перевод и примечания В.С.Таскина. Москва, Изд-во Наука, ГРВЛ
- Материалы по истории древних кочевых народов группы Дунху*, 1984. Введение, перевод и комментарии В.С.Таскина. Москва, Изд-во Наука, ГРВЛ
- Сүхбаатар Г.*, 1971. Сяньби нарын угсаа гарал, соёл, аж ахуй, нийгмийн байгуулал (нэн эртнээс м.э. IV зуун). Улаанбаатар, ШУАХ
- Сүхбаатар Г.*, 1980. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал (МЭӨ IV–МЭ II зуун). Улаанбаатар, ШУАХУ
- Таскин В.С.*, 1980. Материалы по истории ухуаней и сяньби. -История и культура востока Азии. Дальний Восток и соседние территории в средние века. Новосибирск, Наука. 54-102
- Фань Вэнь-лань*, 1958. Древняя история Китая от первобытно-общинного строя до образования централизованного феодального государства. Москва, Изд-во АН СССР
- Шан Юэ, Ли Жужань, Сун Цзесян*, 1959. Очерки истории Китая. Москва
- Чэн Чжунмянь*, 1958 (2004). Түрэгийн түүхийн товчоон. Доорд дэвтэр. Бээжин, УХХ [хятад хэлээр]
- Chavannes É.*, 1905. Les pays d'occident d'après le Wei Lio. -T'oung Pao. Série II. Vol. VI. Leide, pp. 519-571